



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/531

Арвайхээр


Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх үүргээ зөрчиж архи, согтууруулах ундаа худалдаалсан Хархорин сумын 1 дүгээр багт үйл ажиллагаа явуулж буй “Дөрвөн бэрх” хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий зөрчил гаргасан дээрх худалдааны газарт хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа О.Ганбат), Хархорин сумын Засаг дарга (Ч.Алтанбагана)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101211